МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 13/1, Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
E-mail: undeg@ndaatgal.mn, http://www.ndaatgal.mn

2024.03.27 № 01/606.

танай_____-ны №_____-т

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА

Мэдээлэл хүргүүлэх тухай

Азийн хөгжлийн банкны "Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт" төслийн хүрээнд 2019 оны 01 дүгээр сард зохион байгуулсан тендерт шалгарсан Ай Ти Зон ХХК нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулснаар 2016-2018 онуудад зөвлөх байгууллагын боловсруулсан "Системийн бүтэц, шаардлагыг агуулсан ажлын даалгавар"-ыг гүйцэтгэх ажил эхэлсэн.

Нийгмийн даатгалын салбарт дээрх ажлын даалгаврын дагуу гүйцэтгэсэн мэдээллийн нэгдсэн шинэ системийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс үе шаттай нэвтрүүлж байгаа бөгөөд шинэ системийн ажлын явц, үр дүн болон олон нийт, хэвлэл мэдээллийн байгууллагаар хийсэн ажлын мэдээлэл, танилцуулгыг хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА Л.МӨНХЗУЛ

My doc.SBG A-4 /24.03/-r sar

1524070725

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
2024 оны 03 дугаар сарын 27-ны
өдрийн 01/[illegible] тоот албан бичгийн
хоёрдугаар хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН ШИНЭ СИСТЕМИЙН ТАЛААР 2024 ОНД ОЛОН НИЙТ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛЛАГААР МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГАА ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

1. Хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилсан үйл ажиллагааны талаар

Нийтдээ 23 (давхардсан тоогоор) хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 31 удаа (давхардсан тоогоор) нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, нийгмийн даатгалын мэдээллийн шинэ систем (цаашид "шинэ систем" гэх)-ийн талаар иргэд, даатгуулагчдад мэдээлэл хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг эх сурвалж, мэдээллээр хангав. Үүнд:

Телевизийн ярилцлага, шууд нэвтрүүлэг

- НДЕГ-ын дарга Л.Мөнхзул: MNB телевизийн "Цаг үе, үзэл бодол", "Парламент телевиз"-ийн "Ярих өнцөг", "EAGLE TV"-ийн "Зочны цаг" нэвтрүүлэгүүдэд шууд ярилцлагад оролцсон;
- НДЕГ-ын газрын дарга нар, мэргэжилтнүүд болон холбогдох байгууллагын ажилтнууд: нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэл, "Нийгмийн даатгалын системийн шинэчлэл, нийгмийн даатгалын үйлчилгээний талаар "EAGLE TV"-ийн "Зочны цаг" нэвтрүүлэг, TV9 телевизийн "Хэлэлцүүлэг" шууд нэвтрүүлэг, Монгол HD телевизийн "Нүүдэл шийдэл" нэвтрүүлэг болон C1, ETV, NTV, 25 TV, Star TV, TV-9 телевизүүдэд тус тус ярилцлага өгсөн.

Хэвлэлийн бага хурал

НДЕГ-т дараах чиглэлээр хэвлэлийн бага хурлууд зохион байгууллаа.

- Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад зориулсан хэвлэлийн хурал, сургалт уулзалтыг зохион байгуулж, MYOHPT, Mongol HD, UBS TV, ETV, SBS TV, TV5, EAGLE TV, болон gogo.mn, news.mn, unuudur.mn, shuud.mn, Өглөөний сонин, Зууны мэдээ сонин зэрэг 30 хэвлэл мэдээллийн байгууллагын 65 сэтгүүлч ажилтнуудыг хамруулав.
- Шинэ системийн нэвтрүүлэлт, үйл ажиллагааны талаар хэвлэлийн хурал зохион байгуулж, товч.mn, MNB, C1, ETV, EAGLE TV, Монгол HD зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл өгсөн;
- Шинэ системийн ажлын явц, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан илгээх, лавлагаа, тодорхойлолт авахтай холбоотой мэдээллийг C1, 25 TV, EAGLE TV, STAR TV, NTV, TV9 телевизүүдээр дамжуулан олон нийтэд хүргэсэн.

Вэб сайтуудад нийтлүүлсэн мэдээлэл

- news.mn, ikon.mn, gogo.mn, medee.mn, dorgio.mn, mass.mn, shuud.mn сайтуудаар "Нийгмийн даатгалын системийн шинэчлэлтэй холбоотойгоор НДЕГ-ын дэргэдэх

мэдээллийн технологийн төвийн захирал Г.Хүрэлбаатар, ITZ ХХК-ийн дэд захирал нартай хийсэн ярилцлагыг нийтлүүлсэн.

- zuv.mn мэдээллийн сайтад "Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний, амаржсаны, ажилгүйдлийн тэтгэмж" асуудлаар мэдээлэл өгсөн.

2. **Нийгмийн сүлжээний хуудас (фэйсбүүк), вэбсайтаар ирүүлсэн санал хүсэлтэд хариулах, олон нийтийг мэдээллээр хангах талаар**

- Иргэд, даатгуулагчдын санал хүсэлтэд шуурхай хариулах, эргэх холбоог хангах зорилгоор ажиллуулж байгаа @sigomongolia сошиал хуудасны чатбот мессенжерт нийт 19,426 иргэн хандсанаас, автомат хариулагчаас 11,010 иргэн, цахим үйлчилгээний холбоос руу шилжсэн 2,385 иргэн байгаа бол 119 иргэн тухайлсан гомдол илгээснийг цаг тухайд нь шийдвэрлэж, 6,242 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, тухай бүр шийдвэрлэсэн.

- Байгууллагын www.ndaatgal.mn вебсайтад нийт 280,642 иргэд, даатгуулагчид хандсанаас Нүүр хэсэгт 157,412, Иргэд даатгуулагчид цэст 15,157, Аж ахуй нэгж, байгууллага 60,681, Цахим үйлчилгээ цэст 12,700, "Нийгмийн даатгал" аппликэйшнд 8,351, Холбоо барих цэст 12,700, Гар утасны аппликэйшнд 8,351, Санал хүсэлт цэст 3001, Холбоо барих цэст 21,592 иргэд даатгуулагчид хандаж, зөвлөгөө мэдээлэл авлаа.

3. **Нийгмийн сүлжээний хуудас фэйсбүүк, вэбсайтаар бэлтгэж нийтэлсэн контент, постерийн талаар:**

Нийгмийн даатгалын хууль тогтоомж, мэдээллийн шинэ систем, үйлчилгээ, цаг үеийн мэдээллийг олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд www.ndaatgal.mn вебсайт болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим хуудас @sigomongolia сошиал постер мэдээлэл 38, аудио , видео шторк 10, подкаст 1, цаг үеийн 22 буюу нийт 71 удаагийн мэдээллийг бэлтгэн түгээсэн.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын
2024 оны 03 дугаар сарын 04-ны
өдрийн 01/606 тоот албан бичгийн
нэгдүгээр хавсралт

НИЙГМИЙН ДААТГАЛЫН МЭДЭЭЛЛИЙН ШИНЭ СИСТЕМ НЭВТРҮҮЛЖ БАЙГАА АЖЛЫН ЯВЦ, ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

1. Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн систем, программ хангамжийн өнөөгийн байдал

Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд 50 гаруй байгууллага өндөр хурдны шилэн кабелийн нэгдсэн сүлжээнд холбогдсон. Төв, орон нутгийн 31 нэгжид нийт 57 сервер компьютер, 6 өгөгдөл хадгалах төхөөрөмж, 1000 орчим ажлын компьютер, 300 гаруй зөөврийн компьютер болон дагалдах бусад тоног төхөөрөмж, сүлжээний аюулгүй байдлын техник хангамжууд ашиглагдаж байна.

Нийгмийн даатгалын шинэ тогтолцоонд шилжсэнээс хойших 29 жилийн өгөгдөл мэдээллийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа ба сүүлийн 23 жилийн мэдээллийг бүртгэлд суурилан үүсгэж, түүнээс өмнөх жилүүдийн мэдээллийг цахим баримтын сан үүсгэн ашиглаж байна.

Нийгмийн даатгалын салбар нь ямар нэг гадны төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байгаагүй бөгөөд сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд мэдээллийн технологийн мэргэжилтэй 10 хүний бүрэлдэхүүнтэй нэгж, үүнээс 4 программ зохиогч ажиллаж, 60 гаруй программ хангамжийг өөрийн хүний нөөцөөр хөгжүүлэн нэвтрүүлснээс эрүүл мэндийн даатгалын чиг үүрэг ЭМДЕГ-т шилжсэнээр 2023 оны байдлаар 45 программ хангамж, мэдээллийн системийг идэвхтэй ашиглаж байсан.

Мэдээллийн технологийн эдгээр дэд бүтцэд тулгуурлан 73 багц мэдээлэл (сервис) бэлтгэн төрийн мэдээлэл солилцооны ХУР системд байршуулж, төрийн 20 гаруй байгууллага, банк, санхүүгийн болон бусад байгууллагатай цахимаар мэдээлэл солилцох, мэдээллийн үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлсэн. Мөн нийгмийн даатгалын үйлчилгээний 70 гаруй хувийг цахимжуулан ажилласан. Тухайлбал:

- Нийгмийн даатгалын дэвтэр, тэтгэврийн дэвтрийг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн;
- Ажил олгогчид зориулсан вэб хуудсаар нийгмийн даатгалын шимтгэл идэвхтэй төлж буй 60 орчим мянган ажил олгогч 100 хувь цахимаар, үүнээс 25 хувь нь тоон гарын үсгээр тайлангаа ирүүлсэн;
- Эрүүл мэндийн 1200 орчим байгууллагаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны эмнэлгийн хуудсыг цахимаар хүлээн авч даатгуулагчид тэтгэмж олгох үйлчилгээ үзүүлсэн;
- "Нийгмийн даатгал" аппликейшн, "Даатгуулагчдад зориулсан вэб" систем, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia, төрийн үйлчилгээний ТҮЦ машин зэрэг сувгуудаар иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, харилцагч байгууллагуудад 30 орчим үйлчилгээг цахимаар хүргэж, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа тодорхойлолт авах үйлчилгээг цахимжуулсан.

2. Нийгмийн даатгалын мэдээллийн системийн шинэчлэл хийх үндэслэл, шаардлага

Нийгмийн даатгалын байгууллага нь сүүлийн 20 жилийн хугацаанд 60 гаруй программ хангамж, мэдээллийн системийг хөгжүүлэн ашиглаж ирсэн. Эдгээр программ хангамж, мэдээллийн систем нь ялгаатай цаг хугацаанд, янз бүрийн технологи дээр хийгдсэн учир бусад төрийн байгууллагуудын мэдээллийн системтэй уялдан ажиллахад тодорхой хүндрэлүүд үүссэн. Мөн эдгээр салангид, олон программ хангамжийн тогтвортой үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, хөгжүүлэлт шинэчлэл хийхэд цаг хугацаа их алдаж байсан.

Түүнчлэн нийгмийн даатгалын төв, орон нутгийн салбар 40 нэгж (21 аймаг, 9 дүүрэг, сумын 10 тасаг) тус тусдаа сервер компьютер дээр өөр хоорондоо үл хамааралтай мэдээллийн системийг ашиглаж ирсэн бөгөөд мэдээллийг нэгтгэн төвлөрүүлэхийн тулд нэгж бүрт бүрдүүлсэн мэдээллийг нэгтгэж мэдээллийн нэгдсэн сан үүсгэн хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байсан нь динамик автомат бус шинжтэй тул мэдээллийг түргэн шуурхай нэгтгэх боломжид саад учруулж байсан.

Иймд мэдээлийг түргэн шуурхай нэгтгэх, боловсруулах болон төвлөрсөн мэдээллийн сан бий болгож мэдээллийг нэг цэгээс хүргэх, нийгмийн даатгалын үйлчилгээг шуурхай үзүүлэх зорилгоор мэдээллийн системийг орчин үеийн технологи дээр суурилсан төвлөрсөн мэдээллийн сантай, хуулийн өөрчлөлтийг уян хатан зохицуулах боломжтой шинэ систем болгон өөрчлөх шаардлага тавигдсан.

3. Нийгмийн даатгалын системийн шинэчлэл, хөгжүүлэлтийг хариуцан гүйцэтгэж байгаа байгууллагын мэдээлэл

2016-2018 онд "Системийн бүтэц, шаардлагыг агуулсан ажлын даалгавар"-ыг зөвлөх байгууллага боловсруулснаар Азийн хөгжлийн банкны "Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт төсөл"-ийн хүрээнд 2019 оны 1 дүгээр сард зарласан тендерт сонирхол илэрхийлсэн нэр бүхий ХХК (Интерактив ХХК, Аствишн ХХК, ITZone ХХК)-аас тус банкны чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалтын аргаар ITZone ХХК шалгарсан болно. ITZone ХХК 2019 оны 7 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулснаар системийг шинэчлэх, хөгжүүлэх ажлыг 2019-2023 онд гүйцэтгэж байна. Төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам НДЕГ-тай хамтран хэрэгжүүлж байна. Төслийн төсөвт өртөг нь 979.7 мянган ам.доллар байсан.

Гэрээ байгуулснаас хойш 12 сарын дотор системийг нэвтрүүлж, үүнээс хойш 12 сарын хугацаанд системийн засвар үйлчилгээг гүйцэтгэх нөхцөлтэй байсан боловч КОВИД-19 цар тахал болон зөвлөх байгууллагын ажлын гүйцэтгэлээс шалтгаалан системийн хөгжүүлэлт, нэвтрүүлэлтийн ажил хойшилсон гэсэн тайлбарыг ITZone ХХК өгч байна.

4. Системийн шинэчлэл хийх бэлтгэл ажлын талаар

Гүйцэтгэгч ITZone ХХК нь 2019 оны 10 дугаар сараас нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа, ашиглагдаж буй системүүдтэй танилцаж, НДЕГ-аас тавигдсан 1121 шаардлагын дагуу 13 систем, 500 орчим дэлгэцийн үйл ажиллагааны диаграммыг боловсруулж, 2020 оны 1 дүгээр сард баталсан системийн дизайны дагуу 2020 оны 9 дүгээр сараас хөгжүүлэлтийг эхлүүлсэн.

НДЕГ-аас төслийг дэмжиж хамтран ажиллах зорилгоор 3 удаа ажлын хэсэг байгуулж, заавар, зөвлөгөөг тогтмол өгч, хамтран программыг тестэлж ажилласан. Төсөл эхэлж, системийн хөгжүүлэлт хийгдэж эхэлсэн эхний үе нь цар тахлын цаг үетэй

давхацсан нь багагүй хүндрэл учруулсан ч цахим уулзалтуудыг тогтмол зохион байгуулж, хамтран ажилласнаар дараах үр дүнгүүд гарсан. Үүнд:

- Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд "Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программ хангамж", "Хүний нөөцийн систем", "Үндсэн хөрөнгө, бараа материалын бүртгэлийн систем"-ийг 2020 оноос 5 нэгж дээр туршиж, 2022 оноос 34 нэгжид нэгэн зэрэг нэвтрүүлж, 2 жил тогтвортой ажиллаж байна.
- Нийгмийн даатгалын сангийн бүтээгдэхүүн үйлчилгээ, нягтлан бодох бүртгэлийн цогц системийн суурийг дэвшилтэт технологи дээр хөгжүүлж, 14 дэд систем, 87 модулийн ажил хийгдсэн.
- 2022 оны сүүлийн хагас жилд Хан-Уул дүүрэг дээр цогц системээр бүтээгдэхүүн бүртгэх бааз хөрвүүлэлтийн туршилтын ажил хийгдсэн.
- 2023 онд НДЕГ-ын байгуулсан ажлын хэсгээс нийгмийн даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ тус бүрээр 100 гаруй төрлийн шалгах хуудас гаргаж, гүйцэтгэгч байгууллагатай хамтран туршиж шалгасан.
- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 2023 оны 12 дугаар сараас программын бодлогын даалгаруудыг боловсруулан хүргүүлсэн.
- Шинэ системийн ашиглалтын сургалтад НДЕГ, ННДГ, 21 аймаг, 9 дүүргийн 1165 байцаагч, ажилтнуудыг танхимаар болон цахимаар хамруулсан.

5. Шинэ систем нэвтрүүлж эхэлсэн ажлын явц, гүйцэтгэл, үр дүн

Шинэ системийг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үе шаттайгаар нэвтрүүлж, 91.3 мянган даатгуулагч сайн дураар даатгуулах болон тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох хүсэлт ирүүлсэн (үүнээс 41.7% нь цахимаар хүсэлтээ илгээсэн)-ээс 2024 оны 3 дугаар сарын 18-ны байдлаар дараах үйлчилгээг үзүүлээд байна. Үүнд:

1.Нас барагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийг 1 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн нэвтрүүлж, 2.5 мянган иргэнд;

2.Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх үйлчилгээг 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, 31.9 мянган даатгуулагчид;

3.Жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоох, олгох үйлчилгээг 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж 14.4 мянган даатгуулагчид;

4. Ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох үйлчилгээг 01 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн нэвтрүүлж, 5.24 мянган даатгуулагчид;

5.Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж авах хүсэлтийг 02 дугаар сарын 06-ны өдрөөс эхлэн нэвтрүүлж, 26.3 мянган даатгуулагчид;

6.Шинээр тэтгэвэр тогтоолгох болон тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 10.9 мянган иргэний хүсэлтийг шийдвэрлэсэн;

7. Эхний 3 сард сар бүр 520.0 орчим мянган тэтгэвэр авагчийн бүх төрлийн тэтгэврийг хугацаанд нь олгосон;

8.Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авах үйлчилгээг 02 дугаар сарын 15-наас нэвтрүүлснээр 44.1 мянга ажил олгогчоос 722.0 мянган даатгуулагчийн 1 дүгээр сарын, 22.1 мянган ажил олгогчоос 308.4 мянган даатгуулагчийн 2 дугаар сарын тайланг цахим системээр илгээснийг хүлээн авч байталгаажуулаад байна;

9.Ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайланг хүлээн авах, шалгах, баталгаажуулахад тодорхой хугацаа шаардаж байгаатай уялдан 2024 оны 1 дүгээр сарын цалин хөлснөөс тэтгэвэр, тэтгэмжээ тооцуулах үйлчилгээ түр хүлээгдэж байсан. Одоогийн байдлаар 1 дүгээр сарын НДШ-ийн тайланг баталгаажуулж дууссан тул энэ үйлчилгээ сааталгүй явах боломж бүрдсэн.

10. Даатгуулагч, ажил олгогчид нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн 2023 оны лавлагаа, тодорхойлолтыг цахимаар авах үйлчилгээ хэвийн явагдаж байгаа бөгөөд 2024 оны лавлагааг цахимаар авах үйлчилгээг 3 дугаар сарын 15-аас эхлэн portal.ndaatgal.mn веб хуудас болон төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал E-mongolia систем дээр тус тус нээлээ. Мөн 3 дугаар сарын 18-наас эхлэн төрийн мэдээлэл солилцооны ХУР системд ажил олгогч, даатгуулагчдын шимтгэл төлөлтийн мэдээллийг байршуулж эхэлсэн.

11.Шинэ систем нэвтрүүлсэнтэй холбоотойгоор 2024 оны 1 дүгээр сараас хойш олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр НДЕГ-ын болон ITZone ХХК-ийн удирдлагууд, ажилтнууд 3 удаа хэвлэлийн бага хурал зохион байгуулж, 73 хэвлэл мэдээллийн байгууллагаар 151 удаа ярилцлага өгсөн бөгөөд НДЕГ-ын цахим хуудас, Call centre-ээр 15.6 мянган дуудлагад тухай бүр хариу өгч, НДЕГ болон салбар нэгжүүдэд тогтмол утас ажиллуулж тухай бүр иргэд, даатгуулагчид, ажил олгогчдын асуудлыг шийдвэрлэж байна.

6. Шинэ системийг нэвтрүүлснээр үүсэх эрсдэлийг шийдвэрлэсэн байдал

Шинэ систем нэвтрүүлж эхэлсэнтэй холбоотойгоор харилцагч байгууллагуудтай хамтран ажилласнаар ажил олгогч, даатгуулагчдад эрсдэл, хүндрэл үүсгэхгүй байх зорилгоор дараах ажлыг зохион байгуулаа. Тухайлбал:

- ажил олгогчтой хөдөлмөрийн болон бусад гэрээний дагуу ажиллаж байгаа даатгуулагчийн 2023 оны 12 дугаар сарын эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөлтийг үндэслэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлэх чиглэлээр ЭМДЕГ-тай хамтарч ажилласнаар 2024 оны 1, 2 дугаар сард 259.8 мянган даатгуулагч эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, үүнээс 68.8 мянган даатгуулагч эмийн үнийн хөнгөлөлтийн үйлчилгээ авсан байна;
- Нийгмийн даатгалын газруудаас цаасаар олгосон 2023 оны 12 дугаар сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн:
    - ажил олгогчдод бизнесийн, даатгуулагчдад орон сууцны, цалингийн болон хэрэглээний зээлийг хэвийн олгох чиглэлийг арилжааны банкуудад хүргүүлж хамтран ажилласнаар тухайлбал, банкны системд нөлөө бүхий 4 банкнаас 2024 оны 1 дүгээр сараас 3 дугаар сарын 15 хүртэл хугацаанд 603.1 мянган ажил олгогч, хүн зээл авсан байна;
    - тендер шалгаруулалтыг зохион байгуулах чиглэлээр Төрийн худалдан авах ажиллагааны газар болон харъяа байгууллагуудтай;
    - тусгай зөвшөөрөл авах, сунгах зэрэг чиглэлээр холбогдох яамд, Авто тээврийн үндэсний төвтэй тус тус хамтран ажиллаж мэдээлэл солилцсон.

7. Шинэ системийн шилжилтийн явц, онцлог

Шинэ системийг оны эхнээс нэвтрүүлж байгаа боловч дараах нөхцөл байдлын улмаас үе шаттай шилжиж байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулга 2024 оноос хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан өмнө хөгжүүлсэн системд 300 орчим нэмэлт, өөрчлөлт, хөгжүүлэлт хийх зайлшгүй шаардлага үүссэн;

- 20 гаруй жилийн хугацаанд бүрдүүлсэн өмнөх системээс их хэмжээний буюу 3.0 сая гаруй хүний үндсэн мэдээлэл, 500.0 мянган тэтгэвэр авагчийн тэтгэвэр тогтоолт болон сар бүрийн олголтын мэдээлэл, 60.0 мянган ажил олгогчийн болон 1.0 сая орчим даатгуулагчийн сар бүрийн цалин хөлс, шимтгэл төлөлтийн мэдээлэл, эдгээртэй холбоотой менгөн хөрөнгийн гүйлгээ, нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл (DATA)-ийг хервүүлэх ажил хийгдсэн;
- Нийгмийн даатгалын байгууллага нь орлого төвлөрүүлэх (ажил олгогч, даатгуулагчдыг нийгмийн даатгалд хамруулах), зарлага гүйцэтгэх (тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгох) гэсэн санхүүгийн 2 урсгалтай үйл ажиллагаа эрхэлдгээрээ чиг үүргийн хувьд бусад төрийн байгууллагуудаас онцлогтой. Нийгмийн даатгалын нийт 40 гаруй төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээ байдаг ч системчлэхэд нэг бүтээгдэхүүн олон хэсэгт задардаг, тухайлбал, зөвхөн өндөр насны тэтгэвэр 12 төрөлтэй, даатгуулагч тус бүрийн шимтгэл төлсөн хугацаа, нас, хүйс, хөдөлмөрийн нөхцөл зэргээс шалтгаалж янз бүрийн кейс үүсч байгаа нь системийн нэвтрэлтийн хугацаанд нөлөөлж байна.

8. Шинэ систем нэвтрүүлсний давуу тал, үр дүнгийн талаар

Шинэ систем нь ажил олгогчийн шимтгэл төлөлтийн тайлан, сайн дурын даатгалын, тэтгэврийн, тэтгэмжийн бүтээгдэхүүн үйлчилгээг хамарсан цогц систем болсон. Шинэ системийг бүрэн нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

- Одоогийн байдлаар нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжилт 70 гаруй хувьтай байгаа бол бүрэн цахимжина;
- Нэгдсэн мэдээллийн сангийн бүрдүүлэлт цаг хугацааны хоцрогдолгүй бодит цагийн горим (real time)-оор үүсч байгаа тул хэрэглэгчид (иргэд, даатгуулагчид, ажил олгогчид, төрийн болон бусад байгууллагууд) нийгмийн даатгалын үйлчилгээ (тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох, мэдээлэл солилцох, шаардлагатай лавлагаа, тодорхойлолт авах зэрэг)-г цаг хугацаа, орон зайнаас үл хамааран шуурхай авах боломжтой болно;
- Систем нь уян хатан, динамик суурьтай тул хууль тогтоомжийн өөрчлөлт болон хэрэглэгчийн хүсэлтийн дагуу богино хугацаанд системийн хөгжүүлэлтийг хийх боломж бүрдэнэ;
- Мэдээллийн системийг ашиглахтай холбоотой үйлчилгээний болон урсгал зардлын төсвийг хэмнэнэ, зардал буурна;
- Мэдээллийн аюулгүй байдал сайжирна;
- Мэдээллийн давхардалгүй болж, бүртгэлд суурилсан цахим хяналтын үйл ажиллагаанд дэвшил гарна.
- Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудын гар ажиллагаа багасч, ажлын ачаалал тэнцвэржиж, иргэдэд зөвлөгөө өгөх, үйлчлэх ажилдаа илүү цаг зарцуулах боломж бүрдэнэ.

9. Цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Цаашид шинэ системийг бүрэн нэвтрүүлэх, системийн хэвийн ажиллагаа, тогтвортой байдлыг хангах зорилгоор 2024 оны ажлын төлөвлөгөөний дагуу дараах ажлыг зохион байгуулна. Үүнд:

- Нэгдүгээр улиралд шинэ системийг нэвтрүүлж, нийгмийн даатгалын үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хэвийн ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ;

- Хоёрдугаар улиралд нийгмийн даатгалын үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэвийн ажиллагааг тогтворжуулж, нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан, балансыг шинэ системээр гаргана;
- Шинэ системд суурилан нийгмийн даатгалын үйлчилгээг бүрэн цахимжуулна.